

НИЙСЛЭЛ ХОТЫН ЗАХИРГАА БАЙГУУЛАГДСАН НЬ, ТҮҮНИЙ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Ю.Дуламрагчаа

Товч агуулга: Энэ өгүүлэлд нийслэл хотын захиргаа анх байгуулагдсан болон түүний бүтэц, зохион байгуулалт, засаг захиргааны хуваарийн өөрчлөлтийг архивын сурвалж хэрэглэгдэхүүнд тулгуурлан тодруулахыг оролдсон.

Түлхүүр үг: Шар бөсийн орд, Их Хүрээ, Нийслэл Хүрээ, Улаанбаатар хот, хотын түр захиргааны хэрэг эрхлэх газар, хэлтэс, хотын түр захиргааны дүрэм, хот сайжруулах комисс, хороо, орлогч дарга, арван, тогтмол хурал, цаг зуурын хурал

Халх Монголд хувилсан анхдугаар Богд Өндөр гэгээн Занабазарын Шар бөсийн орд 1639 онд байгуулагдсанаасаа хойш хөгжлийн явцад Их Хүрээ, Нийслэл Хүрээ, Улаанбаатар хэмээн нэр нь өөрчлөгдсөөр иржээ. Манай судлаачид нийслэл хотын түүхийг 1950-иад оноос ултай судалж, нэг сэдэвт зохиол, хамтын бүтээл, өгүүлэл олныг туурвисан боловч Нийслэл Хүрээг анх хотын статустай болгож, хотын захиргаа байгуулагдсан, хотын захиргааны дотоод бүтэц, үйл ажиллагаа, засаг захиргааны хуваарийн өөрчлөлтийн талаарх судалгаа дутмаг, гүехэн байдаг.

Тиймээс эл өгүүлэлд архивын сан хөмрөгөөс шинээр илрүүлсэн сурвалж хэрэглэгдэхүүнд тулгуурлан уг сэдвийг тодруулахыг зорив.

1921 оны 7 дугаар сарын 6-нд Монгол Ардын Намын Төв Хороо, Ардын Түр Засгийн газар Нийслэл Хүрээнд хүрэлцэн ирж, 7 дугаар сарын 10-нд Засгийн эрхийг Ардын Засгийн газарт шилжүүлжээ. Энэ үеэс Ардын Засгийн газрын Дотоод явдлын яам нийслэл хотын түр захиргаа байгуулагдах хүртэлх хугацаанд Нийслэл Хүрээний дотоод амьдралыг эрхлэн зохицуулж байсан хэдий ч хувьсгалын дараа бий болсон шинэ нөхцөл байдал, зорилт нь нийслэлд өөрийн захиргаа байгуулахыг зүй ёсоор шаардаж байв.

1923 оны 10 дугаар сарын 13-нд Монгол Ардын Намын Төв Хорооны Тэргүүлэгчдийн хурлаар нийслэл хотын захиргааг байгуулах тухай хэлэлцэж, Засгийн газраас хотын захиргааны дүрэм, эрх үүргийг боловсруулах тусгай комиссыг байгуулахаар тогтжээ. “Тусгай комиссын гишүүн Цэрэндорж, Элбэгдорж нараас”¹ “Монгол улсын хотын түр захиргааны дүрэм”-ийг боловсруулан 1924 оны 3 дугаар сарын 7-нд Засгийн газрын хуралд оруулан хэлэлцүүлж, батлуулжээ.

¹ МАН-ын баримтын төв, Х-4. Д-1. ХН-243. т.10.

Эл дүрэм батлагдсанаар нийслэл хот болон Монгол улсын хэмжээнд хотын түр захиргаа байгуулах явдлыг зохицуулах эрх зүйн үндэс тавигдав.

Тус дүрмийн үндсэн дээр хотын ардын хурал, хотын захиргааг байгуулахаар Нийслэл Хүрээний 23 хорооны Ардын хурлыг зарлан хуралдуулж, хотын цаг зуурын хурлын төлөөлөгчөөр 45 хүнийг сонгож, хотын түр захиргааны анхдугаар хурлыг 1924 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр Дотоод явдлын яамнаа 36 хүний бүрэлдэхүүнтэй хуралдуулж, зохион байгуулалтын асуудлыг хэлэлцжээ. Уг хурлаар хотын захиргааг “Нийслэл хотын түр захиргааны хэрэг эрхлэх газар” хэмээн нэрлэж, “Дотоод явдлын яамнаас “Нийслэлийн түр захиргааны хэргийг эрхлэх газрын захиргаа” гэсэн үсэгтэй хотын захиргааны тамгыг баталж,”² хотын түр захиргааны даргад Моононгийн Баяр, гишүүдэд Бүрнээбаатар, Чимэдцэрэн, Базарваань, Гомбожав, орлогчдод Мээрэн, Нэрэнхүү, вангийн Сандуйжав, мэйрэн Галсан, Дотоод яамны нярав бичээч Батсүх нарын 9 хүнийг сонгожээ. Улмаар Хотын түр захиргааны хэрэг эрхлэх газар, хороодын дарга нарын хамтран хуралдсан 1924 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн хурлын 5 дугаар тогтоолоор “Хотын түр захиргааны газарт Ерөнхий, Алба татвар, Ариутган засах, Үйлдвэр хэмээх 4 хэлтэс зохиож, мөнхүү захиргааны газрын гишүүн 5 хүний дээр туслах гишүүн 4, бичээч 4, Орос, Хятад орчуулагч нижгээдийг нэмж, туслах гишүүнд сар бүр 55 лан, бичээч, орчуулагчид 40-өөд лангийн хэрэглэл олгуулж, няравыг туслах гишүүнд хавсаргах”³-аар хэлэлцэн тогтсон байна.

Зураг 1. Хотын түр захиргааны хэрэг эрхлэх газрын захиргааны аппарат /1924он/



Хотын түр захиргааны дүрмийн наймдугаар зүйлд зааснаар “тус хотын түр захиргааны хурлыг тогтмол ба цаг зуурын хэмээн 2 ангилах бөгөөд тогтмол хурлыг 2 сард 1 удаа хуралдахаас гадна хэрвээ онц чухал хэрэг тохиолдвол цаг зуурын хурлыг зарлан хуралдуулах”⁴-аар заасан байна. Цаг зуурын хурлыг нийслэл хотын түр захиргааны хэрэг эрхлэх газраас тусгай зарлах буюу эсхүл бүх гишүүдийн арваны хоёр хувиас доошгүй нь санал гаргаваас зарлан хуралдуулж болдог байжээ.

Мөн дүрэмд зааснаар хотын хурлын гишүүдийн гурваны хоёр хувиас дээш нь цугларсан тохиолдолд хурлыг нээж, анх удаа хуралдаж буй бол бүх гишүүд зөвлөлдөн тус хурлын гишүүдийн дотроос хурлын дарга ба дэд дарга, нарийн бичгийн дарга тус бүр нэгийг 1 жилийн хугацаагаар сонгох журамтай.

² Дүгэрсүрэн, Л. Улаанбаатар хотын түүхээс. УБ., 1999. т. 98.

³ НАГ, Х-1. Д-1. ХН-23. т. 9.

⁴ НАГ, Х-1. Д-1. ХН-24. Б-1.

Хотын Түр Захиргааны Хэрэг Эрхлэх газрын хурлаар аливаа хэргийг хэлэлцэн тогтооход хурлын гишүүд өөр өөрийн саналыг нууц ба илэрхий гэсэн хоёр хэлбэрээр өгөх ба хотын түр захиргааны хэрэг эрхлэх газрын дарга болон гишүүдийг сонгох, огцруулах зэрэг хэрэг мөн өөр зүйлийн онц чухал хэргийг шийдэхдээ тус хуралд оролцогч гишүүдийн арваны хоёр хувиас доошгүй нь хүсвэл асуудлыг хэрхэн шийдэх саналыг нууцаар авч болдог байжээ. Хэрэв нууцаар санал хураах тохиолдол гарвал тусгай зурвас цаасанд зөвшөөрсөн, эсэхийн тэмдгийг зурж, битүүмжлээд хурлын даргад өгөх ба уг тэмдгийг чухам ямраар зурах явдлыг мөнхүү хурлын дарга зааж өгөх үүрэгтэй байна.

Хотын Түр Захиргааны Хэрэг Эрхлэх газрын дүрмийн арван хоёрдугаар зүйлд, аливаа хэргийг хэлэлцэхэд хуралдсан гишүүд хэлэлцээд олонхийн санал нийлж зөвшөөрснөөр таслан тогтоох ёстой ба хэрэв гишүүдийн санал тэгш хуваагдсан тохиолдолд тус хурлын даргын саналыг харгалзан үзэж хэргийг шийдэхээр заажээ.

Хотын хурлын эрхэлбээс зохих хэргүүдийг тогтоохдоо:

- Хотын түр захиргааны хэрэг эрхлэх газрын дарга, гишүүдийг сонгох огцруулах хэргийг хянан хэлэлцэж Дотоод яамнаа мэдүүлэн батлуулах
- Харьят газрын аливаа албан хаагчдын хүнс хэрэглэл ба бага зэрэг албаны хүмүүсийн орон тоог хэлэлцэн тогтоох
- Харьят хотын доторх хороодыг хэрхэн байгуулахыг эрхлэн тогтоож, мөн хороодын ба хорооны захирлын дагаж явах дүрмийг зохион тогтоох
- Хотын дотор ард олонд тустай газар, үйлдвэр зэргийг хэрхэн байгуулах ба мөн хотын харьяат газрыг хэрхэн тэгшлэн засаж сайжруулах зэрэг явдлыг хянан хэлэлцэж, Дотоод яамнаа мэдүүлэн батлуулж гүйцэтгэх
- Хотыг сайжруулах тухайн эл зардлыг харьяат хотын дотор суугчдаас дотоод, гадаад хэмээн ялгаварлахгүй ашиг хөрөнгийн байдлыг харгалзан зүй зохисоор татвар хураах хэргийг хэлэлцэн тогтоох
- Харьят түр захиргааны хэрэг эрхлэх газар сургаал, заавар өгөх
- Мөнхүү түр захиргааны хэрэг эрхлэх газрын хэрхэн хэрэг явуулсныг хянан байцааж шүүмжлэн хэлэлцэх
- Харьят түр захиргааны газрын орлого, зарлагын дансыг хянан хэлэлцэж Дотоод, Сангийн яамнаа мэдүүлэн батлуулах
- Тус хотын нэрээр бусдаас мөнгө зээлдэх буюу өр төлөх явдлыг хэлэлцэн тогтоож, Сангийн яамнаа мэдүүлэн батлуулж гүйцэтгэх
- Харьят хотын түр захиргааны элдэв хэргийг байцаан шүүмжилж залруулан тэгшитгэх ба хотыг сайжруулах хэргийг хянан хэлэлцэж санал гаргуулах комисс байгуулбаас зохих бөгөөд мөнхүү комиссоор нийслэл хүрээнд болбоос 10 хүн бусад хотод болбоос тус тус 6 хүнийг сонгон томилж гаргах, мөнхүү комиссын гишүүдийн хагас хувийг тус хотноо бүхий гадаад улсын харьяат нараас сонговоос зохих учир хэрхэн сонгох явдлыг харьяат хурлаас эрхлэн тогтоовоос зохих
- Мөнхүү захиргааны хэрэг эрхлэх газраа мэдүүлсэн хэрэг зүйлийг хянан хэлэлцэж, таслан тогтоох

- Аливаа газруудаас хэлэлцүүлэхээр шилжүүлсэн эл хэрэг зүйл ба тусгай хууль дүрмийн ёсоор гүйцэтгэвээс зохих хэргүүдийг хянан хэлэлцэх
- Харьяат захиргааны орлого, зарлагыг хянан байцаах комисст 3-5 хүртэлх хүнийг тус хурлын гишүүдээс сонгох ажлууд байна хэмээн заасан байна.

Хотын Түр Захиргааны Хэрэг Эрхлэх газраас хурал болох газар, цаг хугацаа, хэлэлцэх асуудлуудыг харьяат хурлын гишүүд, олон хороодод бичгээр зарлан илгээдэг байжээ.

Мөн Хотын Түр Захиргааны Хэрэг Эрхлэх газрын дүрмийн арван тавдугаар зүйлд түр захиргааны газрын эрхлэх ажил үүргийг заасан байдаг. Үүнд:

“Харьяат Хотын Түр Захиргааны Хэрэг Эрхлэх газрын эрхэлбээс зохих хэргүүд нь:

- Харьяат хотын хурал хуралдах газрыг засан бэлтгэх
- Харьяат хотын доторх хороодын захирлыг батлах
- Тус хотын дотор сууж бүхий эл дотоод, гадаадын хүн иргэний өрх амын тоо ба нэр овог, нас, уул нутаг захиргаа, орон байшин хөрөнгө зүйлийг жил бүр нэг удаа нарийвчлан байцааж тусгай данс үйлдэж, хадгалах⁵
- Хотыг сайжруулах тухайн зардлыг хотын хурлын тогтсон ёсоор айл бүхнээс буюу орон байшин, аж үйлдвэрийн зүйлээс татвар хураахад тус хотын дотор суугчдаас баялаг үгээгүйн байдалд нийлүүлэн шударгыг барьж нийгэмчлэн хуваан гаргуулах
- Харьяат хотын доторх гудамж зээл тэгшлэн засаж сайжруулах
- Хотын доторх хог бүртгийг сайнаар арилгуулж газар орныг цэвэр ариун байлгахыг хичээх
- Тус хотын дотор буюу орчин тойронд суваг боомт зэргийн олонд тусгай зүйл байгуулах ба тэгшлэн засах, хямгадах хэргийг эрхлэх
- Хотын доторх өнчин, бэлбэсэн, ядуу хүмүүсийг асран тэнхрүүлж хүмүүжүүлэх тусгай орон сав байгуулах
- Хотын дотор галын аюулыг сэргийлэх ба сөнөөх хэргийг эрхлэн оролдох тусгай газар байгуулах
- Хотын дотор галын аюулыг сөнөөх ба ард олны уух идэхэд чухал хэрэглэгдэх худаг ус малтаж гаргуулах”⁶ хэмээн заасан байна.
- Нийслэл хотын Түр Захиргааны Хэрэг Эрхлэх газар нь анх Чойжин ламын сүмийн болон Ёнзон хамба ламтны зүүн талд нэг айлын хашаанд эсгий гэрт байрлаж үйл ажиллагаагаа эхэлсэн байна.

Нийслэл Хүрээнд Хотын Түр Захиргаа байгуулагдахаас өмнө тусгайлан тогтоож өгсөн нутаг дэвсгэр, үндсэн харьяат иргэд байгаагүй юм.

Судлаач Ч.Жамбал “1925 онд Улаанбаатарын хүн ам 61,0 мянга орчим байсны 14750 буюу 24 хувь нь ард иргэд, 20,0 мянга буюу 33 хувь нь шавилан суух данстай лам нар, 26276 буюу 43 хувь нь гадаадын харьяат, худалдаа-мөнгө хүүлэгчид...”⁷, харин судлаач Х.Мэндсайхан Улаанбаатар хотын жинхэнэ

⁵ НАГ-ын сан хөмрөгт 1924-1931, 1934, 1937, 1940, 1944, 1950, 1955 онуудад нийслэл хотод оршин суугчдын болон гадаадын иргэдийн дэлгэрэнгүй бүртгэл, судалгаа хадгалагдаж байна.

⁶ НАГ, Х-1. Д-1. ХН-24. Б-1.

⁷ Жамбал. Ч. Орчин үеийн Улаанбаатар. УБ., 1984. т. 24.

харьяат “1925 онд... 15 мянга болж, цаашид улам өссөөр байжээ”⁸ гэж тус тус тэмдэглэжээ.

Үүнээс үзэхэд, “Хотын түр захиргаа” байгуулагдсанаар Нийслэл хотын үндсэн харьяат иргэд бий болж, жил ирэх тусам өсөн нэмэгдэж байсан ажээ.

1924 оны 6 дугаар сарын 27-нд Засгийн газрын хурлаар хотод газар нутаг олгох асуудлыг хэлэлцэж, хотын “төв хэсгээс гадагш эргэн тойрон найман зүгт арван таван газраар”⁹ хэмжээлэн тусгай газар нутгийг эзэмшүүлэн өгчээ. 1 газар нь 360 алд буюу 576 метртэй тэнцэх бөгөөд дунд насны эрэгтэй хүний алдыг 1 метр 50 см-ээр тооцдог байжээ. Тэгвэл тухайн үеийн хэмжээсээр Нийслэл Хүрээний эзэмшил нутаг нь 234,4 км² байжээ гэж тооцож болохоор байна.

Улсын анхдугаар Их Хуралд Нийслэлийн ард олны дотроос дөрвөн төлөөлөгч сонгон томилох тухай Дотоод явдлын яамнаас тушаасныг Хотын Түр Захиргаа, хороодын дарга нарын хурлаар хэлэлцээд “Хотын Түр Захиргааны Хэрэг Эрхлэх газраас Цогтбадамжав, Базарваань, Данзан, Балдандорж нарыг томилж”¹⁰ байсан бол төд удалгүй тус төлөөлөгчдийн зарим нь хэлмэгдэж, албан тушаал нь өөрчлөгдсөний улмаас Хотын Түр Захиргаа, хороодын дарга нарын 1924 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 11 дүгээр хурлаар гишүүдийг шинэчлэн томилох асуудал хэлэлцэгдэж, Улсын Их Хуралд оролцох төлөөлөгчдөөр Г.Гэлэгсэнгэ, Ц.Дамбадорж, Нацаг зэрэг хүмүүсийг шинээр томилжээ.

Хотын Түр Захиргааны Хэрэг Эрхлэх газраас 1924 оны 5 дугаар сард “хотын хороодыг цөөтгөж, тус тусын хэсэг бүлгээр ялган салгаж, Дунд гол, Дарьганга, Засагт хан, Баруун Сэлбэ, Цоохор, Дархан ван, Түшээт хан, Баруун дамнуурчин, Сэцэн хан, Олон яам, Харчууд, Зүүн Сэлбэ, Консулын дэнж хэмээн тус бүр нэрийдэж, бүгд 13 анги хороо болгож, мөнхүү хороодын газар хурал нээлгэж, дарга нарыг сонгон”¹¹ үйл ажиллагааг нь эхлүүлсэн байна.

Шинээр зохион байгуулагдсан хороодын нэр нь хороодын нутаг дэвсгэрийн байршлаар нэрлэгдсэн бөгөөд тус хороод нь хэзээнээс тоогоор нэрлэгдэх болсон талаарх баримт одоогоор илэрч олдоогүй байна.

Нийслэлийн Архивын баримтыг шүүрдэн үзвэл, 1924 оны байдлаар хороодын дарга нараар:

- 1 дүгээр хорооны даргаар Дашбалдан /Дарьгангын хороо/
- 2 дугаар хорооны даргаар Дугарсүрэн /Засагт ханы хороо/
- 3 дугаар хорооны даргаар Сандуйжав
- 4 дүгээр хорооны даргаар Даш /тус хороо нь дотроо 30 арвантай байжээ./
- 5 дугаар хорооны даргаар Дорж /Дархан ван, Цоохор/
- 6 дугаар хорооны даргаар Баатар /Түшээт ханы хороо/
- 7 дугаар хорооны даргаар Түмэнбаяр /Баруун дамнуурчны хороо/
- 8 дугаар хорооны даргаар Орших /Дунд голын хороо/
- 9 дүгээр хорооны даргаар Дашдоной /Сэцэн ханы хороо/

⁸ Мэндсайхан.Х. Монгол улс дахь гадаадын иргэдийн харьяаллын асуудал /1921-1940/.УБ.,2012.т. 30.

⁹ МАН-ын баримтын төв, Х-4. Д-1. ХН-243. т. 95-97.

¹⁰ НАГ, Х-1. Д-1. ХН-23. т. 33.

¹¹ НАГ, Х-1. Д-1. ХН-23. т. 12.

- 10 дугаар хорооны даргаар Намсрай /Амбан ханы хороо,Олон яам/
- 11 дүгээр хорооны даргаар Автаажав /Зүүн сэлбийн хороо/
- 12 дугаар хорооны даргаар Жамбаа /Харчуудын хороо/
- 13 дугаар хорооны даргаар Ишт /Консулын дэнж/ нар тус тус ажиллаж байжээ.

Шинээр байгуулагдсан хороодын дагаж явах дүрмийг боловсруулах комисст Бат-Очир, Цогтбадамжав, Амар нарыг сонгон баталж, тус комисс хороодын дагаж явах дүрэм 17 зүйлийг боловсруулан батлуулжээ.

Уг дүрмээр хорооны зохион байгуулалтыг хийхдээ хотын доторх 250 хаалганаас 500 хаалгыг 1 хороо, 250 хаалга хүрэхгүй буюу хашаагүй айлуудыг 1 бүрийг нэг хаалга болгон бусад хороодод хавсаргаж, хорооны дарга удирдахаар тогтоожээ.

Хааны орд ба хийд хүрээ уг хаалганд үл хамаарах боловч аливаа цагт сэргийлэх, ариутгах цэвэрлэх зэрэг хэрэгт нийт дүрмийн ёсоор захирагдах ёстойг Хотын түр захиргааны газрын дүрэмд заасан байдаг. Хорооны дарга, орлогч нарыг 1 жилийн хугацаатай сонгоно.

Хорооны дарга нарын эрхлэх хэрэг зүйл нь: харьяат хорооны тэмдгийг хадгалах, хэрэв харьяат хорооны дарга чөлөө цаг тохиолдвоос орлогчид тэмдгийг түр хамааруулж захиргааны газар мэдүүлэн батлуулах, хорооны дарга ба арваны дарга хуралдан товчооны хурал байгуулж, аливаа ихээхэн хэрэг зүйлийг хэлэлцвээс зохих бөгөөд олонхийн саналаар таслан шийтгэх, хэрэв санал тэгш хуваагдаас хорооны даргын санал нийлэлцсэнийг баримтлах, харьяат хорооны доторх амгалан байдлыг сахих, буруу гажуу явагчдыг сэргийлэн цагдах, залхаан цээрлүүлэх, гадаадын хүн нарын тэмдэгт бичгийг байцаан үзэж, агуулах эсэхийг гүйцэтгэх, аливаа биеэр дагнах албыг ээлж тэгшийг үзэж шударгаар явуулах, гал түймрийг сэргийлэн сөнөөх явдлыг хүч хавсралцах, харьяат хороодын доторх аар саар зарга зальхайн хэргийг тусгай зааврын ёсоор зүй зохисыг үзэж таслан шийтгэж, дуусган үл чадахыг зохих газар мэдүүлэн шийтгүүлэх, хорооны дотор суух бүх хүн ам, өрх, хөрөнгө, малын тоо дансыг нэг нэгээр нарийн тодорхой үйлдэж жил бүрийн 5 дугаар сарын 1-ний дотор харьяат захиргааны газар мэдүүлэх, Жич, цэрэг эрийн нэр, нас зэрэг тоо бүртгэх явдлыг нарийн тодорхойгоор ялган салгаж данслах, харьяат хорооны газар таслан шийтгэсэн аар саар хэрэгт зохигчдоос торгож шийтгэсэн зүйлээс шимтгэн хоцрогдсон зэргийн орлогыг нарийн тодорхой данс үйлдэж хадгалах, зарцуулах, харьяат хорооны өнгөрсөн жилийн ба эсэргэн жилийн орлого, зарлагыг тайлан бодож төсөвлөсөн данс үйлдэх зэргээр тус хорооны хуралд оруулан сануулж уламжлан захиргаанаа мэдүүлэн батлуулахаас гадна мөнхүү хороодын албан хаагчдын цалин хэрэглэлийг харьяат хотын захиргааны газраас эрхлэн тогтоож тавин олгуулах, тус хороодын газар өнгөрсөн жилийн дотор ямар зүйлийн хэчнээн аар саар зарга зальхайг хэрхэн шийтгэсэн явдлыг хураангуйлан илтгэж, хотын захиргааны цагдан сэргийлэх хэлтэст мэдүүлэн хянан байцаахад бэлтгүүлэх хэргүүд болно гэжээ.

Хотын Захиргааны газраас харьяат хороодын дарга нарт “тийм хорооны даргын” хэмээх үсэг бүхий модон тэмдэг нижгээдийг үйлдүүлэн олгож, албан бичигт баталгаа болгон ашиглуулж байв.

Хороо бүр нь өөрсдийн хуралтай бөгөөд түүнийг тогтмол болон цаг зуурын гэж ангилна. Тогтмол хурлыг сар тутам нэгээс доошгүй, цаг зуурын хурлыг дээд газраас тусгайлан тушаах буюу онц чухал хэрэг тохиолдох, хурлын гишүүдийн гуравны нэг хувь, хорооны ардуудын гуравны хоёр хувиас дээш санал гарсан тохиолдолд зохих газраас зарлан хуралдуулна.

Хот ба хорооны хурлын төлөөлөгчийг 1 жилийн хугацаатай хорооны иргэдийн хурлаас сонгоно. Хотын хурлын төлөөлөгчийн тоог захиргааны газраас тогтоож өгдөг. Хороодын төлөөлөгчдийн ба хорооны ардын хурал, арваны хурлыг хуралд ирэх гишүүд, иргэдийн гуравны хоёр хувь хүртэл ирсэн тохиолдолд хороодын дарга нар хурлыг нээж хурлын даргыг сонгон, хурлын үйл ажиллагааг явуулдаг. Хэрвээ хуралд аливаа асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхэд санал тэнцсэн тохиолдолд хурлын даргын саналыг харгалзан шийдвэрлэдэг байжээ.

“Хорооны хурлын эрхлэх хэрэг зүйл нь: харьяат хороодын нуусан алба татварыг шударгыг барьж гаргуулах, хорооны орлого, зарлагыг хянан хэлэлцэж, хотын захиргааны газар мэдүүлэн батлуулахад бэлтгэх, хорооны доторх олон ардын аливаа зовлон зүдгүүр ашиг тусын явдлыг шүүмжлэн хэлэлцэж хотын захиргааны газар мэдүүлэн хянан шийтгэхэд бэлтгүүлэх, хорооны эрх баригчдын хэрхэн хэрэг явуулсныг хянан байцааж шүүмжлэн хэлэлцэх, хорооны дарга ба туслах дарга, мөн тэд нарын орлогч нарыг тус тус сонгон огцруулах явдлыг хянан хэлэлцэж, хотын захиргааны газар мэдүүлэн батлуулах, хотын хуралд одох хорооны төлөөлөгчийг сонгох, хорооны орлого, зарлагыг байцаах комисст гурван хүнийг нэг жилийн хугацаагаар сонгох, харьяат арваны хурлуудаас мэдүүлсэн эл хэрэг зүйлээс товчооны хурлаар шүүмжлэн хэлэлцээд сая шилжүүлэн ирсэн хэрэг зүйлийг шүүмжлэн хэлэлцэх, харьяат хорооны доторх бага насны хөвгүүд, охидыг бичиг эрдэмд боловсруулан сургуульд оруулахыг хичээх, харьяат хотын хурал ба захиргааны газраас тушаасан албыг хэрэг зүйлийн ёсоор идэвхийлэн гүйцэтгэх”¹² зэрэг байжээ.

Хороо нь дотроо арванд хуваагдана. Хаалга арав хүрвээс арван хаалга тутамд нэг даргыг сонгож, арван хаалга хүрэхгүй 7 өрхөөс доош байвал урьдах арванд хавсаргаж байв. Долоогоос дээш болбол арванд тооцдог байв. Хэрвээ хашаагүй олон гэрүүд байвал өрх бүрийг нэг хаалганд тооцож бодно.

Арван гэрийн эрхэлбээс зохих хэрэг зүйлүүдэд: харьяат арваны дарга, орлогчийг сонгох, огцруулах, харьяат арван хаалганы өрх ам, хөрөнгийн данс ба мөн гадаадын хүний нэмсэн, орсон зэргийн нэрийн тооны дансыг тусгай заавар маягийн ёсоор үнэн шударгаар тодорхойлон үйлдэх, арван хаалганы доторх өрхүүдийн ногдсон алба татварыг шударгыг барьж хуваан гаргуулах, арван хаалганы доторх бага насны хөвгүүд охидыг бичиг эрдэмд боловсруулах, хорооны даргаар уламжлан дээд газраас тушаасан эл хэрэг зүйлийг хэрхэн хугацааны ёсоор идэвхийлэн гүйцэтгэх ба мөн хуралд үл ирэх өрхийн тэргүүлэгч нарыг хэрхэн шийтгэхийг тогтоох”¹³ багтдаг байв.

Арваны дарга орлогчийг 3 сарын хугацаатай сонгодог байв.


Арван хаалганы даргын эрхлэх хэрэг зүйл нь: хүн ам, хөрөнгө, малын

¹² НАГ, Х-1. Д-1. ХН-24. Б-6.

¹³ НАГ, Х-1. Д-1. ХН-24. Б-6.

дансыг хадгалах, харьяат арван хаалганы дотор бүхий сайд дарга, түшмэд нарын хэмээн ялгаварлахгүй нэг адил баримтлан захирах, харьяат арван хаалганы доторх аар саар хэргийг шударгыг барьж зүй зохисыг үзэж таслан дуусгах ба хэрвээ дуусган үл чадах буй аваас харьяат хорооны даргад мэдүүлэн хүргүүлж, хянан шийтгүүлэх, арван хаалганы дэвсгэр газрын доторх гадаадын хүн иргэнийг баримтлан захирах ба мөн дээд газраас хүлээн авсан тамга дарсан хамгаалах бичиг буй аваас зохих газар мэдүүлэн гүйцэтгүүлэх, харьяат арваны хурлын аливаа хэлэлцэн тогтоосон ба дээд газраас тушаасан эл хэрэг зүйлийг ёсоор гүйцэтгэх, харьяат арван хаалганы өрх, ам, хөрөнгийн данс ба мөн гадаадын хүний нэмсэн орсон зэргийн нэрийн тооны дансыг тусгай заавар маягийн ёсоор үнэн шударгаар тодорхойлон үйлдэх хэргийг жил бүрийн 3 дугаар сарын 1-ний дотор эрх биш харьяат хорооны даргад мэдүүлэх, арван хаалганы дотор хэрвээ гамшиг зовлон тохиолдвоос хорооны даргад мэдүүлэн гүйцэтгүүлэх, арван хаалганы харьяа газруудын хог бүртгийг арилган цаг үргэлжид ариун цэвэр байлгах явдлыг өрхийн тэргүүлэгч нарт тулган тушааж гүйцэтгүүлэх ба мөн ёсоор гүйцэтгэж буй үгүйг хянан магадлах, арван хаалганы доторх түр захирагдан буй ардуудын уул харьяат хошууны дансанд оролцоогүй мал ба хотын жинхэнэ харьяат нарын малыг үнэн бүрнээр тодорхойлуулан, өөрсдөөр хуруу дарах ба үсэг зуруулах зэргээр батлуулах, арван хаалганы дотор суугаа ардуудыг дотоод гадаад хэмээн ялгаварлахгүй шударга хянан байцаах”¹⁴ хэмээн заажээ.

Зураг 2. Хорооны бүтэц зохион байгуулалт /1924 он/



Ардын Засгийн газрын 1924 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн хурлаар Нийслэл Хүрээний түүхэнд анх удаа Хотын Түр Захиргааны Хэрэг Эрхлэх газрыг байгуулж, “Хотын түр захиргааны дүрэм”-ийг баталсан нь Нийслэл Хүрээний түүхэнд гарсан шинэ дэвшилт алхам төдийгүй, Монгол улсын засаг захиргааны

¹⁴ НАГ, Х-1. Д-1. ХН-24. Б-6.

зохион байгуулалтад гарсан томоохон өөрчлөлт байв. Энэ үеэс Монгол улсын засаг захиргааны зохион байгуулалтад биеэ даасан “Хот” гэдэг статустай, засаг захиргааны нэгж бий болсон байна.

Хотын Түр Захиргааны Хэрэг Эрхлэх газрын дотоод зохион байгуулалт нь Ерөнхий, Алба татварын, Ариутган засах, Үйлдвэрийн хэмээх 4 хэлтсээс бүрдэж байсан бөгөөд засаг захиргааны хуваарь нь хороо, арванд хуваагдаж, тэдгээр нь тус бүрдээ хуралтай, дарга нь тодорхой эрхэлсэн ажилтай байж, дээд газрын шийдвэрийг хэрэгжүүлэх анхан шатны нэгж болж байлаа.

1924 оны 4 дүгээр сараас Хотын түр захиргаа, олон хороодын дарга нарын хурал бий болж, хотын тулгамдсан асуудлыг хэлэлцэж, тогтоол гарган ажиллах болсон нь хотын захиргааны ажилд хотын иргэдийн саналыг тусган хэрэгжүүлэх, хотын захиргаа, хотын оршин суугчдын хооронд эргэх амьд холбоо бий болгоход чухал үүрэг гүйцэтгэжээ. Энэ нь хотын өнөөгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үндэс суурийг тавьж өгсөн гэж үзэж болохоор байна.

Тухайлбал, тус хурлаар нийслэл хотын түр захиргааны хэрэг эрхлэх газрын дарга, гишүүдийг сонгох,¹⁵ хотын түр захиргааны газрын бүтэц, зохион байгуулалт, байрлах газар, ажилтан албан хаагчдын орон тоо, цалингийн хэмжээг тогтоох,¹⁶ хороодын дарга нарыг томилох, тэдгээрийг орлогч даргатай болгох,¹⁷ хороодын дарга нарын дагаж явах дүрмийг батлах, УИХ-д суух төлөөлөгчдийг сонгох¹⁸ зэрэг асуудлыг хэлэлцэн шийдэж байжээ.

Мөн түүнчлэн хотыг тохижуулах ажилд хэрэглэгдэх зардлыг хотын оршин суугчдаас хөрөнгийн байдлыг харгалзан татвар хураах, эзэмшиж буй хашаа байшингийн газраас түрээс авах¹⁹ зэргээр бүрдүүлж, эдийн засгийн асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэж байв.

Хотын Түр Захиргааны Хэрэг Эрхлэх газрын ажилд туслах зорилгоор 1924 онд Хотын захиргааны дэргэд “Хот сайжруулах комисс”-ыг шинээр байгуулж, хот тохижилтын ажлыг хариуцуулсан байна. Тус комиссын даргаар Г.Гэлэгсэнгэ, нарийн бичгийн даргаар Элбэгт нар ажиллаж, долоо хоногийн Пүрэв гараг бүр хуралддаг байв.

Хот сайжруулах комиссоос өөрийн эрх, үүргийн дагуу хийж хэрэгжүүлсэн анхны томоохон арга хэмжээ нь хотын доторх замын хог, чулууг хотын иргэдээр цэвэрлүүлэх ажил байсан бөгөөд уг асуудлыг Хотын Түр Захиргааны Хэрэг Эрхлэх газар болон хороодын хурлаар хэлэлцүүлсний эцэст ажил хэрэг болгож чадсан юм.

Мөн “Хотын дотор залуу үндэс бүхий мод тарьж ургуулан, газар орныг ариун цэвэр болгох, тусгай цэцэрлэгт хүрээлэн буюу ард олныг зугаацуулах газар бэлтгэх”²⁰, хотод үзэмж болгохоор нисэх онгоц худалдан авах, Нийслэл Хүрээний ард иргэдийн амьдралд тус дөхөм болохуйц худаг малтуулах”²¹, усан хөөргийг

¹⁵ НАГ, Х-1. Д-1. ХН-23. т. 6.

¹⁶ НАГ, Х-1. Д-1. ХН-23. т. 7.

¹⁷ НАГ, Х-1. Д-1. ХН-23. т. 27.

¹⁸ НАГ, Х-1. Д-1. ХН-23. т. 31-33.

¹⁹ НАГ, Х-1. Д-1. ХН-23. т. 13-16.

²⁰ НАГ, Х-1. Д-1. ХН-23. т. 39.

²¹ НАГ, Х-1. Д-1. ХН-28. т. 6-7.

хотын мэдэлд шилжүүлэн авах²², морь мал, өвс түлээний худалдаачдын худалдаа хийх газрыг зааж зохицуулах²³, махны сав байшинг байгуулах²⁴ зэрэг олон арга хэмжээнүүдийг анхааралдаа авч, комиссын хурлаар хэлэлцэн шийдвэрлэж байжээ.

Энэ нь Нийслэл Хүрээний түүхэнд урьд өмнө байгаагүй цоо шинэ байгууллага бөгөөд тогтсон хугацаанд тогтмол хуралдан, хурлаас тогтоол гарган хэрэгжүүлж байсан нь хотын хөгжил, хот тохижилтод үлэмж тусыг үзүүлжээ.

Abstract: *The cabinet meeting of People's government has approved "The Municipal temporary regulation" according to which the Municipal Temporary Administrative Agency was established in 7th March 1924. This can be observed as one of progressive steps, not only for Niislel Huree's history, but also for the Mongolian Administrative structure. Since that period, the Mongolian administrative structure has got an independent body as a "city" administration unit.*

Municipal temporary administrative agency had four departments such as General, Tax or financial, Disinfection and Industry. Administration unit including sub-units as Khoroo and Arvan, have own meetings and own Heads to implement governmental actions and decisions.

²² НАГ, Х-1. Д-1. ХН-23. т. 17.

²³ НАГ, Х-1. Д-1. ХН-28. т. 3.

²⁴ НАГ, Х-1. Д-1. ХН-28. т. 3.